

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар ТӨЛӨВЛӨЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ

Т.Цэндсүрэн Доктор, дэд профессор
МУБИС БСС Нийгмийн ажил арга зүйн тэнхим

Иргэний оролцоот төр



Хэрэгцээ, үндэслэл

Зах зээлийн маркетингийн
(бизнесийн байгууллагын)
үндсэн зарчим, аргуудыг
ашиглаж хүн амын эрсдэлт
зан үйлд өөрчлөлт хийх замаар
нийгмийн сайн сайхан байдлыг
дээшлүүлэх тухай

- Ниймийн ажлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, тодорхой сонгосон бүлгүүдэд нөлөөлөхөд
- Олон нийтийн түвшинд өөрчлөлт хийх, хандлагад нөлөөлөхөд ашиглах боломжтой

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн болон бүхэл нийгмийн ашиг тусын тулд,
- Тодорхой зан байдлын сайн дураар хүлээн зөвшөөрөх, эсэргүүцэх, өөрчлөх, татгалзуулах зорилгоор\
- Сонгосон бүлэгт /зорилтот бүлэгт/ нөлөөлөх ажиллагаа юм.

Зан байдлын өөрчлөлтийг борлуулах
Өөрчлөлтийг агент нь:

- Шинэ зан байдлыг хүлээн зөвшөөрүүлэх
- Боломжит зан байдлыг үгүйсгэх
- Одоогийн зан байдлыг өөрчлөх
- Хуучин зан байдлаасаа татгалзахыг зорилтот бүлгээс шаарддаг.

Өөрчлөлтийг бий болгож болно


- Мэдлэг боловсрол
- Итгэл үнэмшил,
- Хандлага, мэдрэмж




ХБИ ЧИГЛЭСЭН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

- Нийгмийн амьдралын сайн сайхан төлөв байдал /social welfare-social wellbeing/
- нийгмийн халамж гэсэн утгаар хэрэглэгдэх нь маш түгээмэл болсон байна.

Нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүд (ХБ) нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүний болон нийгмийн капиталыг нэмэгдүүлэх зорилготой.



ХБИ ЧИГЛЭСЭН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ



Нийгмийн халамжид хэн ч дуртай байдаггүй-зардлыг гаргаж буй татвар төлөгчид ч, тэднийг төлөөлж байгаа улс төрчид ч дургуй мөн халамж хүртэж байгаа ядуу иргэдийн авч байгаа мөнгө нь хангалтгүй, ядуусыг дорд үзсэн байдаг учраас тэд ч дургуй.

(Давид Элвүүд)

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ШИНЭЧЛЭЛ**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭЧЛЭЛ

**1. Иргэдийн
хэрэгцээнд
суурилсан
үйлчилгээ**

**2. Ил тод
байдал
иргэний
оролцоо**

**3. Оновчтой
чиг үүрэг**

**4. Үр дүнд
суурилсан
удирдлага**

**5. Мэдлэг
чадвартай
хүний нөөц**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

- Нийгмийн хязгаарлагдмал нөөцийг зөвхөн нийгмийн эмзэг бүлэгт тодорхой хүрээний хүмүүст зарцуулах, эсвэл хүний аж байдлын сайн сайхныг төрд даатгах зэрэг зарчмын ялгаатай үзэл бодлуудаас илүү нийгмийн хөгжлийн чиг хандлагыг баримтлах
- Хүний аж байдлын сайн сайхан төлөв байдлыг хангахад чиглэгддэг чиг хандлагууд, тухайлбал филантропи /өглөг хандив/, нийгмийн ажил, нийгмийн удирдлага
- Нийгмийн хөгжлийн чиг хандлага нь хүний аж байдлын сайн сайхан төлөв байдлыг хангах бодлогыг эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй шууд холбож өгдөг. (J.Midgley)

- Нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүд нь нийгмийн капиталыг нэмэгдүүлэх зорилготой байх
- Хөгжилд чиглэсэн нийгмийн ажлын үр дүнд нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс чадавхжиж цаашдаа нийгмийн халамж, асрамжаас хараат байхаа больж болно.
- Ядуурлыг бууруулж эдийн засгийн өсөлтийг хангах, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай уялдуулах

Нийгмийн бодлого нь үнэт зүйлсээр дамжин нийгмийн амьдралд нэвтэрч хэрэгждэг ч гэсэн үзэл суртлаас ангид байх чиг хандлага байдаг бөгөөд харин тухайн бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны мөн чанар дээр анхаардаг.

- Нийгмийн бодлого нь нийгмийн асуудалтай хөндөгдөн гардаг. Харин нийгмийн асуудлын талаар дараах хандлагууд өргөн дэлгэрчээ.
- Функциональ хандлага Социал институтууд, байгууллагууд нийгмийн зорилгоо биелүүлэхийн тулд чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг тайлбарлахыг эрмэлздэг. Хэрэв тэдгээр институтууд үр ашигтай ажиллаж чадахгүй байгаа бол шалтгааныг нь судалдаг байна.
- Асуудалд сөргөлдөөний үүднээс ханддаг судлаачид социал бүтэц, институтууд ямагт сайн ажиллах ёстой гэж үздэггүй. Зөрчил сөргөлдөөн социал институтийн салшгүй хэсэг бөгөөд эдгээр нь нийгмийн асуудлыг нөхцөлдүүлнэ. Нийгмийн асуудал бол нөөц дутагдалтайн улмаас үүдэн гардаг сөргөлдөөний үр дүн гэж үздэг.

- Нийгмийн эмгэгийн баримтлал. /Social pathology/ Энэ хандлагад нийгмийг хүний бие организмтай адилтган үзэж, судалж байв. Хувь хүн, социал институтууд хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлаас хоцорч, үүний улмаас нийгмийн организмын эрүүл саруул үйл ажиллагаа алдагдаж, нийгмийн асуудал гарч ирнэ гэж үздэг. Нийгмийн асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж байхгүй бол нийгэм аажмаар хүнлэг бус шинжтэй болно гэж үзэж байв.
- Нийгмийн зохион байгуулалт алдагдах /Social disorganization/ Энэ нь мөн функциональ хандлагад багтана. Дэлхийн II дайны дараа шилжин суурьшилт, хотжилтын үйл явц хүчтэйявагдаж, том хотод шилжин ирсэн олон хүн хотын амьдралд түргэн дасч чадахгүй, гадуурхагдаж байв. Архидалт, мансууруулах бодис хэрэглэх явдал, гэмт хэрэг, оюуны хомсдол, өссөн. Онолын шинэ баримтлалыг үндэслэгчид хүмүүсийн хүсэн хүлээж байсан зүйл үл биелэгдэн, итгэл найдвар алдахын хамт нийгэм эмх журамгүй болно гэж үздэг. Энэ үйл явц нь нэгдүгээрт, биеэ хэрхэн авч явж, ямар үйл байдлыг дагах ёстойг заасан дүрэм, журам, хэм хэмжээ дутагдах, хоёрдугаарт өөр өөр соёл хоорондоо зөрчилдөх, гуравдугаарт хууль дүрмийг чанга сахин мөрдсөн хэр нь тус болохгүй харин ч хохирох, уналт сүйрлээр төгсөх байдлаар илэрнэ. Эдгээр дарамт нь хувь хүний төдийгүй нийгмийн зохион байгуулалт алдагдаж, эмх журамгүй байдал өсөхөд хүргэнэ.
- Үнэт зүйлсийн зөрчлийн баримтлал. Дэлхийн II дайны дараа гарч ирсэн. Гаж үйл байдал нь хувь хүн хийгээд нийгмийг хууль дүрэм зөрчигдөх, бүтэлгүйтэх явдалд зайлшгүй хүргэх албагүй. Нийгмийн хувьд төвөгтэй асуудал нь тодорхой бүлгийн хувьд ердийн, хууль ёсны байж болно гэж үзэх болсон. Иймээс нийгмийн асуудлыг бүлгийн үнэт зүйстэй үл нийцэх нөхцөл байдал хэмээн тодорхойлдог.
- Гаж үйл байдлын баримтлал. /Deviant-behavior/. Хэм хэмжээнээс хазайсан үйл байдлыг нийгмийн асуудал хэмээн тодорхойлдог. Зорилгод хүрэх легитим арга хэрэгслийг хэрэглэхэд саад учирсан үед нийгмийн асуудал гарч ирдэг. Гаж үйл байдалтай хүмүүс үйл байдлын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишигтэй харилцах явдлыг нэмэгдүүлэх замаар тэднийг дахин нийгэмшүүлэх нь гаж үзэгдлийг багасгах хамгийн дөт арга зам гэж үздэг.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

SWOT дүн шинжилгээ

Давуу тал

Боломж

Сул тал

Аюул
занал

